



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 322

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол Кувейтын байгаль хамгаалах төв" төрийн өмчит аж, ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, 39,500,000.00 (гучин есөн сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 29,070,833.42 (хорин есөн сая далан мянга найман зуун гучин гурван төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 3 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Монгол Кувейтын байгаль хамгаалах төв" төрийн өмчит аж, ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Х.Ерхуланд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөгчийг оруулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Автомашиныг худалдсаны дараа автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) -г үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001735

16-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 13 ны өдрийн
322 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ КУВЕЙТЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ, АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН
ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Киа Бонго /Kia Bongo/, улсын дугаар 62-96 УБЕ, арлын дугаар KNVWF03428K307627	2015.06.01	15,500,000.00	11,495,833.42	4,004,166.58	4,100,000.00
2	Тоёота Альфард /Toyota alphasard/, улсын дугаар 54-62 УБТ, арлын дугаар ATX100025404	2015.10.01	15,500,000.00	11,345,833.42	4,154,166.58	4,200,000.00
3	Тоёота Приус /toyota prius/ улсын дугаар 78-23 УБС, арлын дугаар 035033	2015.10.01	8,500,000.00	6,229,166.58	2,270,833.42	2,300,000.00
			39,500,000.00	29,070,833.42	10,429,166.58	10,600,000.00
	Нийт дүн		39,500,000.00 (гучин есөн сая таван зуун мянга)	29,070,833.42 (хорин есөн сая далан мянга найман зуун гучин гурван төгрөг дөчин хоёр мөнгө)	10,429,166.58 (арван сая дөрвөн зуун хорин есөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг тавин найман мөнгө)	10,600,000.00 (арван сая зургаан зуун мянга)